

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН 2010 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Илтгэгч нь: Ерөнхий шүүгч Ц.Зориг

Эрхэм шүүгч, ажилтнуудаа!

Бид өнгөрч буй жилд шүүх эрх мэдэл, түүн дотроо шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг эрх зүйн хүрээнд тодорхой, нээлттэй, нарийвчилсан байдлаар боловсронгуй болгож хуульчлах, түүнийг төлөвшүүлэх, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийг шинээр байгуулах, шүүхийн захиргааны удирдлагыг зорилтот стратегид суурилсан алсын хараатайгаар хэрэгжүүлэх, гадаадын зарим орнуудтай хамтран зохион байгуулж буй шүүгчдийн сургалтыг тогтмолжуулах, түүний үр нөлөөг дээшлүүлэх, Улсын Дээд шүүхээс хууль тайлбарласан албан ёсны тайлбарыг болон эрүү, иргэн, захиргааны хэргийн шийдвэрийг эмхтгэн нийтийн хүртээл болгох зэрэг зорилтыг тус тус дэвшүүлэн ажилласан бөгөөд энэ чиглэлүүдэд зарим тодорхой үр дүн, ахиц гарч үүнд та бүхний идэвхи зүтгэл, санал санаачлага хамгаас чухал байсныг тэмдэглэхэд таатай байна.

Улиран буй 2010 он ажил хөдөлмөр өрнүүн, амжилт бүтээлээр арвин жил байлаа.

Та бидний хөдөлмөр зүтгэлийг Монголын төр өндрөөр үнэлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгч С.Нямжав “Монгол Улсын Гавъяат хуульч цол”-оор, П.Цэцгээ “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-оор, захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч Ш.Даваадулам, жолооч Б.Энхжаргал нар “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар тус тус шагнагдлаа.

Мөн шүүгч С.Батдэлгэр Улсын Дээд шүүхийн “Хүндэт тэмдэг”-ээр, шүүхийн статистик, тоон мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн Д.Оюунчимэг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн “Хүндэт тэмдэг”-ээр, жолооч Г.Батчулуун Монголын Залуучуудын Холбооны “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч цол, тэмдэг”-ээр тус тус шагнагдлаа.

Түүнчлэн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ хараат бус байж, гагцхүү хуульд захирагдан ажиллаж, аливаа хэрэг, маргааныг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, шүүхийн өөрчлөлт, шинэчлэлтэд зохих хувь нэмэр оруулсан, шүүхийн шийдвэрийг цаг тухайд нь, зохих ёсоор гүйцэтгэн барагдуулж, шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаагаа хууль тогтоомжид чанд нийцүүлэн ажилласан, шүүхийн хүний нөөцийг бэлтгэн бэхжүүлэх, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж МУИС-ХЗС-н Эрүүгийн эрх зүйн тэнхмийн эрхлэгч Ж.Бямбааг Улсын Дээд шүүхийн “Хүндэт тэмдэг”-ээр, Говь-Алтай аймгийн Сум дундын шүүхийн шүүгч Н.Оюунбилэг, Ц.Үйтүмэн, Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхэд шүүгчийн туслах П.Амаржаргал, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны 138 дугаар тойргийн ахлах шийдвэр гүйцэтгэгч Ч.Мэндбаяр, У.Энхсоёл, “Үнэн” сонины сэтгүүлч Д.Мягмаржаргал нарын 6 хүнийг Ерөнхий шүүгчийн захирамжаар Улсын Дээд шүүхийн “Жуух бичиг”-ээр тус тус шагналаа.

2010 он эрдмийн ургац арвин, номын өгөөж дэлгэрсэн он болж өнгөрлөө. Тухайлбал,

- Улсын Дээд шүүхээс 2008-2009 онд хууль тайлбарласан тогтоолыг эмхтгэн хуулийн албан ёсны тайлбарын эмхэтгэл;
- “Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар” ном;
- “Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхтгэл” /эрүүгийн хэрэг/;
- “Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхтгэл” /иргэний хэрэг/;
- “Монгол Улсын шүүхийн шийдвэрийн эмхтгэл” /захиргааны хэрэг/;
- “Шүүхийн 2009 оны ажлын тайлан” зэргийг хэвлүүлж олон нийтийн хүртээл болголоо.

Монгол Улсын Дээд шүүх өмнө нь Хууль зүйн үндэсний төв /хуучин нэрээр/ болон төслийн бусад байгууллагатай хамтран дээрх шүүхийн шийдвэрийн эмхтгэлүүдийг эрхлэн гаргадаг байсан бөгөөд харин энэ жил анх удаа, бие даан өөрсдөө боловсруулж, санхүүжүүлэн 3 цувралыг хэвлүүлж, уншигч түмэнд толилууллаа. Цаашид дээрх эмхтгэлийг эрхлэн хэвлүүлэх ажиллагаа үргэлжлэн хийгдэх болно.

2010 оны 2 дугаар сарын 05-ны өдөр Шүүгчдийн зөвлөл хуралдаж, ШЕЗ-ийн гишүүнээр:

- Төв аймгийн шүүхийн Ерөнхий шүүгч Д.Мягмаржав,
- Хэнтий аймаг дахь Сум дундын 2-р шүүхийн Ерөнхий шүүгч Г.Болормаа нарыг шинээр,
- Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч Д.Дамдиндоржийг улируулан тус тус сонгов.

Түүнчлэн Шүүхийн мэргэжлийн хороо болон Сахилгын хороо, Шүүгчдийн холбооны **2009** онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг хэлэлцлээ.

Улсын Дээд шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүн таслах ажиллагааны дүн мэдээ болон Танхимууд, Тамгын газрын тайлан гарлаа. Ингээд Улсын Дээд шүүхийн **2010** оны **Нэгдсэн тайланг** товч танилцуулъя.



### Нэг. Шүүн таслах ажиллагааны талаар

#### Нийт шүүгчдийн хуралдаан:

**2010** онд нийт шүүгчдийн хуралдааныг **13** удаа зарлан, нийт **12** өдөр хуралдуулж, бүгд **30** асуудал хэлэлцэж, **29** тогтоол гаргасны дотор эрүүгийн хэрэг **13**, иргэний хэрэг **3**, хуулийн тайлбар **9**, бусад асуудал **4**-ийг тус тус хэлэлцэж шийдвэрлэн, **Архангай, Орхон, Өмнөговь, Увс, Хэнтий** аймгийн анхан болон давж заалдах шатны шүүх, захиргааны хэргийн шүүхүүдийн ажлыг шалган тусалсан дүнгийн тухай тэмдэглэл **1** гаргасан байна.

Өнгөрсөн **2009** онтой харьцуулахад Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тоо **3**-аар, хуулийн тайлбар **10**-аар тус тус буурч, эрүүгийн хэрэг **1**-ээр, иргэний хэрэг **2**-оор, бусад асуудал **4**-өөр тус тус нэмэгджээ.

#### Нийт шүүгчдийн хуралдааны үзүүлэлт




**2010 оны шүүн таслах ажиллагааны тайланг товч танилцуулбал:**

**1. Эрүүгийн хэргийн танхим:**

Эрүүгийн хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл 9 хэрэг дээр хяналтын журмаар эрүүгийн 457, цагаатгалын 196, Ерөнхий шүүгчид хандаж гомдол гаргасан 51, нийт 713 хэрэг хүлээн авчээ.

Тайлангийн хугацаанд 345 эрүүгийн, 193 цагаатгалын, нийт 538 хэргийг шүүх хуралдаанаар хянаж шийдвэрлэж, 92 хэргийг хянан буцааж, 51 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлж, одоо 32 хэргийн үлдэгдэлтэй байна.

**Нийт хүлээн авсан 713 хэргээс**



Эрүүгийн хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 73 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 7.4 хэрэг хэлэлцжээ.


Хяналтын журмаар хэлэлцэгдсэн эрүүгийн 345 хэргийн 56.8 хувь буюу 196 хэргийн тогтоол, магадлалыг хэвээр үлдээж, гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, 13.9 хувь буюу 48 хэргийн тогтоол, магадлалд өөрчлөлт оруулж, 29.3 хувь буюу 101 хэргийн тогтоол, магадлалыг хүчингүй болгосон байна.

Өөрчлөлт оруулсан 48 тогтоол, магадлалын 10.4 хувь буюу 5 нь Эрүүгийн хууль буруу хэрэглэсэн, 4.2 хувь буюу 2 нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, 6.3 хувь буюу 3 нь хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн, 79.1 хувь буюу 38 нь шийтгэх тогтоол, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон 101 тогтоол, магадлалтай хэргээс 54 хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт, 19 хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж, 6 хэргийг хэрэгсэхгүй болгож, 18 хэргийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгосон, шийтгэх тогтоол, магадлалын зарим заалтыг хүчингүй болгосон 4 хэрэг байна.

Хяналтын журмаар Танхимын тэргүүн Д.Батсайхан 92, шүүгч Б.Бат-Эрдэнэ 147, С.Нямжав 131, Ч.Ганбат 73, Б.Доржготов 15, Ц.Зориг 6, Д.Пунцаг 2, Ерөнхий шүүгчийн ажлын алба 51 эрүүгийн хэрэг тус тус хүлээн авчээ.


**Шүүгч тус бүрийн болон Ерөнхий шүүгчийн ажлын албаны хүлээн авсан хэрэг**



Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд Танхимын тэргүүн Д.Батсайхан **411**, шүүгч С.Нямжав **501**, Б.Бат-Эрдэнэ **458**, Ч.Ганбат **375**, Б.Доржготов **109**, Ц.Зориг **34** удаа тус тус **оролцсоноос**;

Танхимын тэргүүн Д.Батсайхан **344**, шүүгч С.Нямжав **41**, Б.Бат-Эрдэнэ **29**, Б.Доржготов **15**, Ч.Ганбат **6** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн Д.Батсайхан **69**, шүүгч С.Нямжав **168**, Б.Бат-Эрдэнэ **158**, Ч.Ганбат **114**, Б.Доржготов **26**, Ц.Зориг **3**, хэрэг тус тус **илтгэсэн** байна.



Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн цагаатгалын **193** хэргийн 198 хүнд холбогдох **140** хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгон тэднийг цагаатгаж, давхар цагаатгасан **52** хэргийн магадлалыг хүчингүй болгож, **52** хэргийн тогтоолыг хэвээр үлдээжээ.

**Нийт шүүгчдийн** хуралдаанаар эрүүгийн **13** хэргийг хянан хэлэлцсэн байна.

Хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн **345** хэргийн **82.9** хувь буюу **286** нь ялтан, өмгөөлөгч, хохирогч, тэдний хууль ёсны төлөөлөгчийн **гомдлоор**, **11.9** хувь буюу **41** нь улсын яллагчийн **эсэргүүцлээр**, **5.2** хувь буюу **18** нь прокурорын **дүгнэлтээр** хэлэлцэгджээ.

Тайлангийн хугацаанд Танхимын тэргүүн **Д.Батсайхан 47**, шүүгч **Б.Бат-Эрдэнэ 29**, **С.Нямжав 9**, **Ц.Зориг 3**, **Ч.Ганбат 3**, **Б.Доржготов 1** хэргийг тус тус хянан, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зохих заалтуудыг зөрчсөн, гомдол гаргах хугацаа хэтэрсэн үндэслэлээр, мөн Ерөнхий шүүгчийн ажлын алба **49** хэргийг хянан зохих хариуг өгөх байдлаар тус тус буцаасан байна.

Тус танхим 2010 онд нийт **79** албан бичиг, **123** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Д.Батсайхан **69** албан бичиг, **117** өргөдөл гомдол, шүүгч **Б.Бат-Эрдэнэ 6** албан бичиг, **2** өргөдөл гомдол, **С.Нямжав 4** албан бичиг, **1** өргөдөл гомдлыг тус тус хянан шийдвэрлэж, цагаатгалын ажилтай холбоотой **3** өргөдлийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны **иргэний** хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн Д.Батсайхан **28** удаа оролцсоноос **8** удаа даргалж, шүүгч С.Нямжав **71**, Б.Бат-Эрдэнэ **34**, Ц.Зориг **14**, Ч.Ганбат **56**, Б.Доржготов **6** удаа оролцожээ.

Харин **хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд**:

Танхимын тэргүүн Д.Батсайхан **59** удаа оролцсоноос **7** удаа даргалж, шүүгч Б.Бат-Эрдэнэ **75**, С.Нямжав **73**, Ч.Ганбат **38**, Ц.Зориг **15** удаа тус тус оролцжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж **80**-г гаргаснаас Танхимын тэргүүний “шүүхийн харъяалал тогтоох” захирамж **55**, бусад захирамж **25** байна.

## 2. Иргэний хэргийн танхим:

Иргэний хэргийн танхим өмнөх оны үлдэгдэл **65** хэрэг дээр хяналтын журмаар иргэний **985**, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан **247**, шинээр илэрсэн нөхцөл байдал тооцуулахаар **37**, нийт **1334** хэрэг хүлээн авчээ.

Тайлангийн хугацаанд **984** хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, **18** хэргийг хяналтын журмаар хэлэлцэхээс татгалзаж, иргэний хэргийн харъяалал тогтоолгохоор

ирүүлсэн 4 хэргийн харьяаллыг тогтоож, 38 хэргийг шинээр илэрсэн нөхцөл байдалд тооцуулахаар, 235 хэргийг Ерөнхий шүүгчийн ажлын албанд шилжүүлсний зэрэгцээ Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр 3 хэрэг хянагдаж, одоо 52 хэргийн үлдэгдэлтэй байна.



**Иргэний хэргийн танхимын** хяналтын шатны шүүх хуралдаан нийт 74 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 14 хэрэг хэлэлцэн, нийт 1022 хэрэг хянан шийдвэрлэжээ.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн иргэний 984 хэргийн 59 хувь буюу 581 хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хэрэгсэхгүй болгож, 13.5 хувь буюу 133 хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, 11.5 хувь буюу 114 хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгож, 15.8 хувь буюу 156 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгосон байна.


Өөрчлөлт оруулсан 133 шийдвэр, магадлалын 68.4 хувь буюу 91 нь хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, хэрэглэх ёсгүй хэрэглэсэн, хууль буруу тайлбарлаж хэрэглэсэн, 31.6 хувь буюу 42 нь шүүх хуулиар тогтоосон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон 156 шийдвэр, магадлалтай хэргээс 83.9 хувь буюу 131 хэргийг хушүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, 16.1 хувь буюу 25 хэргийг буюу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон байна.

Шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийг буюу хэргийг хэрэгсэхгүй болгосон, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан 156 хэргийн 79.4 хувь буюу 124 нь шүүх өөр хуулийг, эсхүл хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн, 20.6 хувь буюу 32 нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн байна.

**Хяналтын журмаар** Танхимын тэргүүн Ц.Амарсайхан 96, шүүгч Б.Ундрах 250, А.Доржготов 249, Л.Бямбаа 247, Д.Тунгалаг 228 иргэний хэрэг тус тус хүлээн авчээ.


#### Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг



**Хяналтын шатны** Иргэний хэргийн шүүх хуралдаанд танхимын тэргүүн Ц.Амарсайхан **817**, шүүгч Б.Ундрах **732**, Л.Бямбаа **717**, А.Доржготов **672**, Д.Тунгалаг **647** удаа тус тус оролцсоноос;

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **729**, шүүгч А.Доржготов **71**, Л.Бямбаа **64**, Д.Тунгалаг **46**, Б.Ундрах **34** хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **88**, шүүгч Б.Ундрах **243**, А.Доржготов **240**, Л.Бямбаа **234**, Д.Тунгалаг **217** хэрэг тус тус **илтгэсэн** байна.



**Нийт шүүгчдийн** хуралдаанаар иргэний **3** хэргийг Ерөнхий шүүгчийн дүгнэлтээр хянан хэлэлцсэн байна.

Хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн **41.6** хувь буюу **436** нь нэхэмжлэгчийн, **57.1** хувь буюу **597** нь хариуцагчийн, **1.3** хувь буюу **14** нь гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Тус танхим **2010** оны хагас жилд нийт **63** албан бичиг, **56** өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **57** албан бичиг, **53** өргөдөл гомдол, Л.Бямбаа **1** албан бичиг, Д.Тунгалаг **1** өргөдөл гомдол, Б.Ундрах **1** албан бичиг, **2** өргөдөл гомдлыг тус тус хянан шийдвэрлэж, **4** одоо албан бичгийн үлдэгдэлтэй байна.

Хяналтын шатны **эрүүгийн** хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **63** удаа оролцсоноос **24** удаа даргалж, шүүгч Л.Бямбаа **91**, Б.Ундрах **78**, А.Доржготов **68**, Д.Тунгалаг **43** удаа тус тус оролцожээ.

Харин захиргааны хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн Ц.Амарсайхан **85** удаа оролцсоноос **30** удаа даргалж, шүүгч Л.Бямбаа **105** удаа оролцсоноос **1** удаа даргалж, **1** хэрэг илтгэж, Б.Ундрах **83** удаа оролцсоноос **1** хэрэг илтгэж, Д.Тунгалаг **74** оролцож, А.Доржготов **61** удаа оролцсоноос **1** хэрэг илтгэж тус тус оролцжээ.

Иргэний хэргийн танхим 2010 онд “Үндэсний Жижиг Дунд Үйлдвэр Эрхлэгчдийн Нэгдсэн нам”-ыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзаж, мөн “Монгол Ардын Хувьсгалт нам”-ын XXVI Их хурлаар батлагдсан Монгол Ардын Хувьсгалт намын нэрийг “Монгол Ардын нам” гэж өөрчлөн, намын шинэчилсэн мөрийн хөтөлбөр, намын дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэсэн байна.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж 747-г гаргаснаас шүүгчийн “гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” 10, “гомдолд гаргаагүйд тооцох тухай” 6, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” 174 захирамж, Танхимын тэргүүний “шүүх бүрэлдэхүүн томилох тухай” 536, “улсын тэмдэгтийн хураамж буцаан олгох тухай” 18, “хэргийн харьяалал тогтоох тухай” 3 захирамж тус тус гарчээ.

### 3.Захиргааны хэргийн танхим:


Захиргааны хэргийн танхим давж заалдах болон хяналтын журмаар өмнөх оны үлдэгдэл давж заалдах журмаар гомдол гаргасан 37, хяналтын журмаар гомдол гаргасан 37, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 5, бүгд 79 хэрэг дээр давж заалдах журмаар 536, хяналтын журмаар 308, Ерөнхий шүүгчид гомдол гаргасан 77, нийт 1000 хэрэг хүлээн авчээ.

Давж заалдах журмаар 521 хэргийг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэж, 23 хэргийг хянан буцааж, одоо 30 хэргийн;

Хяналтын журмаар 324 хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж, 7 хэргийг хянан буцааж, одоо 14 хэргийн;

Ерөнхий шүүгчид хянуулахаар ирүүлсэн 82 хэргээс 76 хэрэгт албан бичгээр хариу өгч, одоо 6 хэргийн тус тус үлдэгдэлтэй байна.

Давж заалдах болон хяналтын журмаар нийт хүлээн авсан 1000 хэргээс



Захиргааны хэргийн танхимын хяналтын шатны шүүх хуралдаан нийт 41 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 11, давж заалдах шатны шүүх хуралдаан нийт 41 өдөр хуралдаж, өдөрт дунджаар 15 хэрэг хэлэлцжээ.

Захиргааны хэргийн танхимд давж заалдах журмаар ирүүлсэн 573 хэргээс нэг шүүгчид 115, хяналтын шатны журмаар ирүүлсэн 345 хэргээс нэг шүүгчид 58 хэрэг тус тус ногдож байна.

Хяналтын журмаар хэлэлцэгдсэн захиргааны 324 хэргийн 65.7 хувь буюу 205 хэргийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, 17 хувь буюу 53 хэргийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, 17.3 хувь буюу 54 хэргийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулахаар ирүүлсэн 12 хэргийн хүсэлтийг хангаагүй байна.



Өөрчлөлт оруулсан **53** шийдвэр, магадлалын **24.5** хувь буюу **13** нь хууль буруу хэрэглэсэн, **18.9** хувь буюу **10** нь шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй, **56.6** хувь буюу **30** шийдвэр, магадлалд бусад өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **54** шийдвэр, магадлалтай хэргээс **37** хувь буюу **20** хэргийг хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **1.9** хувь буюу **1** хэргийг хэрэгсэхгүй болгож, **44.4** хувь буюу **24** хэргийн шийдвэрийг хэвээр үлдээж, шийдвэр, магадлал, тогтоолыг хүчингүй болгож нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон **16.7** хувь буюу **9** хэрэг байна.


Давж заалдах журмаар хэлэлцэгдсэн захиргааны **521** хэргийн **62.4** хувь буюу **322** хэргийн шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж, **11** хувь буюу **57** хэргийн шийдвэрт өөрчлөлт оруулж, **26.6** хувь буюу **137** хэргийн шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хүчингүй болгосон, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулахаар ирүүлсэн **5** хэргийн хүсэлтийг хангаагүй байна.

Өөрчлөлт оруулсан **57** шийдвэрийн **49.1** хувь буюу **28** нь хууль буруу хэрэглэсэн, **50.9** хувь буюу **29** нь нотлох баримтыг буруу үнэлсэн гэсэн үндэслэлээр өөрчлөлт оруулжээ.

Хүчингүй болгосон **137** шийдвэр, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолтой хэргээс **65** хувь буюу **89** хэргийг шүүхээр дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж, **24** хувь буюу **33** нэхэмжлэл болон хэргийг хэрэгсэхгүй болгож, **11** хувь буюу **15** хэргийн шийдвэрийг хүчингүй болгож нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байна.

Танхимын тэргүүн О.Зандраа хяналтын журмаар **44**, давж заалдах журмаар **2**, шүүгч Д.Пунцаг давж заалдах журмаар **115**, хяналтын журмаар **62**, Ц.Сумъяа давж заалдах журмаар **115**, хяналтын журмаар **60**, Л.Атарцэцэг давж заалдах журмаар **114**, хяналтын журмаар **58**, П.Цэцгээ давж заалдах журмаар **114**, хяналтын журмаар **56**, Ч.Тунгалаг давж заалдах журмаар **113**, хяналтын журмаар **65** захиргааны хэрэг тус тус хүлээн авчээ.

Шүүгч тус бүрийн хүлээн авсан хэрэг




Давж заалдах шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанд шүүгч Ц.Сумъяа **126**, Ч.Тунгалаг **103**, Л.Атарцэцэг **99**, Д.Пунцаг **99**, П.Цэцгээ **80** удаа тус тус оролцож;

Шүүгч П.Цэцгээ **105**, Ц.Сумъяа **103**, Ч.Тунгалаг **103**, Л.Атарцэцэг **102**, Д.Пунцаг **96** захиргааны хэргийн шүүх хуралдааныг тус тус даргалж;

Шүүгч Ц.Сумъяа **108**, Л.Атарцэцэг **107**, Д.Пунцаг **104**, П.Цэцгээ **104** Ч.Тунгалаг **99** хэрэг тус тус илтгэсэн байна.






**Хяналтын шатны** захиргааны хэргийн шүүх хуралдаанд шүүгч Л.Атарцэцэг 75, Д.Пунцаг 69, Ч.Тунгалаг 64, П.Цэцгээ 60, Ц.Сумъяа 40 удаа тус тус **оролцсоноос**;

Танхимын тэргүүн О.Зандраа 276, шүүгч Л.Атарцэцэг 8, Ц.Сумъяа 4, П.Цэцгээ 4, Д.Пунцаг 2, Ч.Тунгалаг 1, хэргийн шүүх хуралдааныг тус тус **даргалж**;

Танхимын тэргүүн Танхимын тэргүүн О.Зандраа 42, шүүгч Ч.Тунгалаг 60, Д.Пунцаг 59, Ц.Сумъяа 56, П.Цэцгээ 53, Л.Атарцэцэг 52 хэрэг тус тус **илтгэсэн** байна.



Давж заалдах болон хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаанаар шийдвэрлэсэн хэргийн 54.3 хувь буюу 450 нь нэхэмжлэгчийн, 26.3 хувь буюу 217 нь хариуцагчийн, 19.4 хувь буюу 161 нь гуравдагч этгээдийн гомдлоор хянан хэлэлцэгджээ.

Тус танхим 2010 онд нийт 27 албан бичиг, 23 өргөдөл, гомдол хүлээн авснаас Танхимын тэргүүн О.Зандраа 11 албан бичиг, 11 өргөдөл гомдол, шүүгч Л.Атарцэцэг 4 албан бичиг, 2 өргөдөл гомдол, Д.Пунцаг 3 албан бичиг, 3 өргөдөл гомдол, Ц.Сумъяа 2 албан бичиг, 3 өргөдөл гомдол, Ч.Тунгалаг 3 албан бичиг, 2 өргөдөл гомдол, П.Цэцгээ 3 албан бичиг, 2 өргөдөл гомдлыг тус тус хянан шийдвэрлэж, одоо 1 албан бичгийн үлдэгдэлтэй байна.

**Хяналтын шатны эрүүгийн** хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн О.Зандраа 108 удаа оролцсоноос 77 удаа даргалж, шүүгч Д.Пунцаг 67 удаа оролцсоноос 2 удаа даргалж, Л.Атарцэцэг 92, Ч.Тунгалаг 70, Ц.Сумъяа 63, П.Цэцгээ 61 удаа оролцжээ.

Харин **хяналтын шатны иргэний** хэргийн шүүх хуралдаанд:

Танхимын тэргүүн О.Зандраа 90 оролцсоноос 61 удаа даргалж, шүүгч П.Цэцгээ 59 удаа оролцсоноос 10 удаа даргалж, 1 удаа илтгэж, Л.Атарцэцэг 62, Д.Пунцаг 42, Ц.Сумъяа 42, Ч.Тунгалаг 71 удаа тус тус оролцжээ.

Тайлангийн хугацаанд танхимын тэргүүний болон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол 1137 гаргаснаас “шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг хянуулах тухай” 17, “шүүх хуралдааныг хойшлуулах тухай” 102, “гомдол гаргаагүйд тооцох тухай” 2 шүүхийн тогтоол, “гомдол хэлэлцүүлэхээс татгалзах тухай” 1, “гомдол гаргаагүйд тооцох тухай” 18 шүүгчийн захирамж, Танхимын тэргүүний “шүүх бүрэлдэхүүн томилох тухай” 954, харъяалал тогтоосон 37 захирамж, бусад 6 захирамж тус тус гаргасан байна.

## **Хоёр. Мэргэжлийн удирдлагаар хангах ажиллагааны талаар**

Шүүх, шүүгчдийг мэргэжлийн удирдлагаар хангах үндсэн асуудлын цөм нь хуулийг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх талаар хуулийн албан ёсны тайлбар гаргах явдал билээ.

Тайлангийн хугацаанд Улсын Дээд шүүх хуулийн зүйл, заалтыг тайлбарласан нийт 9 тогтоол гаргаж, “Дээд шүүхийн мэдээлэл”, “Төрийн мэдээлэл” сэтгүүлүүдэд нийтлүүлэх, өөрийн вэб сайтад байршуулах зэргээр олон нийтийн хүртээл болголоо. Үүнд:

- Төрийн албаны тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Л.Атарцэцэг, Ц.Сумъяа/
- Ашигт малтмалын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Д.Пунцаг, П.Цэцгээ/
- Эрүүгийн хуулийн 15 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /С.Нямжав/
- Эрүүгийн хуулийн 21 дүгээр бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Б.Бат-Эрдэнэ, Ч.Ганбат/
- Эрүүгийн хуулийн 26 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Д.Батсайхан/
- Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 4 дүгээр дэд бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Ц.Амарсайхан/
- Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай /Д.Тунгалаг/
- Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийг шүүхийн практикт хэрэглэх тухай /С.Нямжав/
- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг шүүхийн практикт дагаж мөрдөх журмын тухай /О.Зандраа, Ч.Тунгалаг/ зэрэг болно.

Дээрх хуулийн тайлбарууд нь тодорхой төрлийн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хууль хэрэглээний асуудлаар гарч байсан хүндрэл бэрхшээлийг арилгах, хуулийг нэр мөр ойлгож, зөв хэрэглэх, тодорхой төрлийн хэргийн зүйлчлэлийг хэргийн нөхцөл байдалд тохируулан оновчтой тогтоох, зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах иргэдийн баталгаа нэмэгдэх, эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд зохих хувь нэмэр оруулж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Мөн хугацаанд эрүүгийн хэргийн танхим зөвлөмж 1, тойм 2, иргэний хэргийн танхим зөвлөмж 3, тойм 2, захиргааны хэргийн танхим зөвлөмж 3, тойм 1, нийт зөвлөмж 7, тойм 5-ийг гарган шүүхүүдэд хүргүүлснээс гадна “Дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлд хэвлүүллээ.

Улсын Дээд Шүүхийн эрүү, иргэн, захиргааны хэргийн танхимын шүүгчид **Архангай, Орхон, Өмнөговь, Увс, Хэнтий** аймгийн шүүхийн ажлыг шалган тусалж, мэргэжлийн удирдлагаар ханган, холбогдох сургалтыг зохион байгууллаа.

Нийт шүүгчдийн хуралдаанаар дээрхи шүүхүүдийн ажлыг шалган тусалсан тухай асуудлыг хэлэлцэж, **тэмдэглэл** гарган холбогдох шүүхүүдэд нь хүргүүлээ.

## **Гурав. Тамгын газрын ажлын талаар**

Тамгын газар нь Шүүхийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гарсан дүрэм, журам, заавар, Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн Ерөнхий Зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх, нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэх талаар анхааран ажиллаж иржээ.

**Авлигын эсрэг хууль, “Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх, хадгалах журам”-д** заасны дагуу шүүгч, захиргааны албан хаагчдаас **“Албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэг”-ийг 2009 оны байдлаар** гаргуулан авч, **17** шүүгчийн материалыг “Авлигатай тэмцэх газар”-т хүргүүлж, захиргааны албан хаагч **1** хүний материалыг Шүүхийн Ерөнхий зөвлөлд, **40** хүний материалыг тамгын газарт зохих журмын дагуу хадгалж байна.

Түүнчлэн “Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан”-г шинэчилсэн програмын дагуу гаргаж, Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүлээ.

Тамгын газрын даргын зөвлөл **6** удаа хуралдаж, Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **20** гаруй асуудлыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

Тамгын газрын дарга хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн нийт **108** тушаал гаргасан байна.

Одоо тамгын газрын харъяа албадын ажлын талаар товч дурдья.

### **1. Ерөнхий шүүгчийн ажлын алба.**

Тус алба нь тайлангийн хугацаанд **18** албан бичиг, **191** өргөдөл, гомдол, хүлээн авч цаг тухайд нь хариуг нь өгсөн бөгөөд одоо **7** өргөдөл гомдлын үлдэгдэлтэй байна.

Ерөнхий шүүгчид гаргасан гомдлыг үндэслэн Ерөнхий шүүгчийн ажлын алба эрүүгийн **51**, иргэний **247**, захиргааны **82**, **нийт 380** хэрэг хүлээн авч Ерөнхий шүүгчид танилцуулснаар Ерөнхий шүүгч иргэний **3** хэргийн тогтоолд хууль зөрчсөн үндэслэлээр дүгнэлт бичиж, Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, дүгнэлт бичигдээгүй **343** хэрэгт хариу өгчээ. Өмнөх онтой харьцуулахад харин иргэний хэрэг **2**-оор өсчээ.

Тайлангийн хугацаанд ажлын албаны дарга, бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах зааварлагчийг байлцуулан хэргийн оролцогчид болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөгч **238** хүнийг сар бүрийн **4** дүгээр **7** хоногийн **пүрэв** гаригт хүлээн авч уулзаж, тэдний санал, хүсэлтийг сонсож, Ерөнхий шүүгчид тухай бүрт нь танилцуулж, зохих хариуг өгч шийдвэрлэжээ.

Мөн хугацаанд тухайн алба нь Ерөнхий шүүгчид хандаж гаргасан гомдлын дагуу эрүү, иргэн, захиргааны хэргийг хянах явцад шүүх, шүүгчдийн болон захиргааны ажилтнуудын гаргасан алдаа, зөрчлийн талаар тусгайлан бүртгэл хөтөлж, давхардсан тоогоор **56** шүүгч, **63** туслах ажилтанд энэ талаар мэдэгдэж, зөвлөмж өгч ажиллажээ.

Түүнчлэн Архангай, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгч, ажилтнуудад Улсын Дээд шүүхээс хийсэн ажил болон Ерөнхий шүүгчээс өгсөн үүрэг даалгаварын талаар мэдээлэл хийжээ.

Цагаатгалын үнэмлэх олгох талаар хэлмэгдэгчдийн төрөл садан болон Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссуудаар дамжуулан **42** өргөдөл, хүсэлтийг хүлээн авч “**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль**”-д заасны дагуу Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн 2006 оны 2 дугаар сарын 03-ны 11 дугаар захирамжийг баримтлан нийтдээ **30** ширхэг үнэмлэх олгосноос **19** үнэмлэхийг /**16949-16967** хүртэлх дугаартай/ хүсэлт гаргагч нарт шинээр олгож, хаяж, үрэгдүүлсэн **11** үнэмлэхийг нөхөн бичиж өгсөн байна.

## **2. Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба.**

Тус алба нь шүүхийн шүүн таслах болон бусад үйл ажиллагаа, мөн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны талаар давхардсан тоогоор сонинд **290**, телевизэд **155**, радиод **64**, вэб сайтуудад **173** мэдээ, мэдээлэл бэлтгэн нийтлүүлж, нэвтрүүлжээ. Мөн телевизүүдийн урсдаг мэдээгээр давхардсан тоогоор **124** мэдээг олон нийтэд хүргэсэн байна. Үүний заримаас дурьдвал:

### **Телевизийн нэвтрүүлгийн хувьд:**

- Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран “Эрх зүйн хөтөч” телесэтгүүлийг иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан “Иргэний эрх зүйн хамгаалалт” сэдвээр, шүүгч А.Доржготов “Гэр бүлийн дундын өмч” сэдвээр, гэр бүлийн, хөдөлмөрийн эрх зүйн сэдвээр шүүх хурлын жүжигчилсэн тоглолт хэлбэрээр тус тус нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэжээ.
- Харин өмчийн маргааны асуудлаар телевизийн зохиомж нэвтрүүлэг бэлтгэж, нэвтрүүллээ.

### **Радиоогийн нэвтрүүлгийн хувьд:**

- Монголын үндэсний олон нийтийн радиоогийн хууль эрх зүйн “Соёмбо” нэвтрүүлгээр “Иргэний болон захиргааны эрх зүйн маргааны шалтгаан, нөхцөл, анхаарах зарим асуудлууд” сэдвээр,
- Монгол Улсын Дээд шүүхээс хууль тайлбарласан тогтоолуудыг иргэдэд мэдээлэл хэлбэрээр тогтмол хүргэж байна.

### **Сонин, нийтлэлийн хувьд:**

- Шүүхийг олон нийтэд сурталчлах, шүүн таслах ажиллагааны хууль зүйн үндсийн талаар шүүгч, шүүхийн ажилтан **25** хүний ярилцлага,
- Тодорхой хэрэг маргаан, түүнийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэртэй холбоотой **41** нийтлэл, өгүүлэл,
- **2010** оны **1, 2, 3** дугаар улирлын шүүн таслах ажиллагааны мэдээ зэргийг тус тус өдөр тутмын болон бусад сонинд нийлүүлсэн байна.

### **Хэвлэлийн бага хурлын хувьд:**

- Монгол Улсын нийт шүүхүүдийн 2009 оны эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүн таслах ажиллагааны талаар,
- Захиргааны хэргийн танхим, Ханнс Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академитай хамтран “Захиргааны хэргийн шүүхийн төлөвшил, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр,
- Нийслэлийн шүүхтэй хамтран нийслэл, дүүргийн шүүхүүдийн шүүн таслах ажиллагааны болон шүүгчийн ажлын ачааллын талаар хэвлэлийн бага хурлыг тус тус зохион байгуулжээ.

Эдгээрээс гадна Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх ажлын хүрээнд хууль эрх зүйн чиглэлээр дагнан мэргэшсэн сэтгүүлчдэд “Шүүхийг сурвалжлах нь” сэдэвт цуврал сургалтыг сар бүр зохион байгуулж хэвшлээ. Тухайлбал,

- “Шүүх эрх мэдэл”,
- “Нэр төр алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, Хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоотой эрх зүйн маргаан, шүүхийн практик”,
- “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа”,
- “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”,
- “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа”,
- “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал”,
- “Эрүүгийн гэмт хэргийн тухай ойлголт, гэмт хэргийн бүрэлдэхүүн, ял шийтгэл”,
- “Эрх зүй болон шүүхийн тогтолцоо”,
- “Шүүхийн хүний нөөцийн асуудал”,
- “Шүүгч, хуульчийн ёс зүй” сэдэвт сургалтуудыг тус тус зохион байгуулж, энэ чиглэлийн зарим шүүхийн шүүгч, захиргааны ажилтнууд хичээл заалаа.

Дээрх цуврал сургалт нь шүүх, хэвлэл мэдээллийн байгууллагын хооронд эргэх холбоо тогтоох, шүүхийн байгууллагын талаар үнэн, зөв, бодит мэдээллийг олон нийтэд түгээх, төлөвшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Түүнчлэн шүүхийн үйл ажиллагааны талаархи олон нийтийн санаа бодлыг тандан судлах, түүнд дүн шинжилгээ хийх зорилгоор шүүхийн талаар 2009 онд өдөр тутмын сонингуудад нийтлэгдсэн мэдээ, мэдээлэлд судалгаа хийн, түүнд тулгуурлан холбогдох албан тушаалтнууд болон зарим шүүхийн шүүгч нарт танилцууллаа.

Цаг үеийн үйл явдалтай холбоотойгоор шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Монголын Шүүгчдийн холбооноос шүүн таслах ажиллагаа, шүүгчийн ёс зүйн талаар гаргасан мэдэгдлийг 2 сонин, 2 телевизээр бүрэн эхээр нь, 3 сонин, 4 телевизээр мэдээ болгон нийтэлж, нэвтрүүлжээ.

Анхан, давж заалдах болон дагнасан шүүхүүдээс 2 сар тутамд шинэ мэдээ, мэдээллийг хүлээн авч Ерөнхий шүүгчид танилцуулан, нэгтгэж, шүүхийн нэгдсэн мэдээллийн системийн вэб сайт [www.judgeinfo.mn](http://www.judgeinfo.mn)-д байрлуулж, сонинд нийтлүүлж, телевизийн урсдаг мэдээгээр олон нийтэд дамжуулсан байна.

Улсын Дээд шүүхэд давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргаж ирүүлсэн эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар эрүүгийн 310, иргэний 580, захиргааны 450 оролцогчдод утсаар болон биечлэн лавлагаа өгч, эрх зүйн мэдээллээр ханган ажиллажээ.

### **3. Шүүхийн судалгааны төв.**

Судалгааны төв нь шүүн таслах ажиллагааны чанар, үр нөлөөг дээшлүүлэх, хуулийг нэг мөр ойлгон, зөв хэрэглэж буй талаар дүгнэлт гаргах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга замыг тодорхойлох, хуулийн тайлбар гаргахад судалгаа хийх, төсөл боловсруулах зэрэгт түлхүү анхааран ажиллажээ.

“Дээд шүүхийн мэдээлэл”, “Монголын төр, эрх зүй”, сэтгүүлийг эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгож байна. Мөн зарим албатай хамтран “Монгол Улсын шүүхийн 2009 оны жилийн тайлан”-г эмхтгэн хэвлүүллээ.

Судалгааны төв нь танхимуудаас ирж буй шаардлагатай судалгааг түргэн шуурхай, бодитой гаргахад анхаарч, судалгааны арга, аргачлалыг сайжруулахад чиглэн ажиллажээ. Тухайлбал, зарим судалгааны ажлаас дурьдвал:

- “Үндсэн хуульд нийцээгүй хуулийг хэрэглэхгүй байх зарчмын хэрэгжилтийн судалгаа”,
- Эрүүгийн хэргийн хугацаа хэтрэлтийн талаарх 2005-2009 оны судалгаа,
- “Төрийн албан хаагчийн гомдлоор шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 2003-2009 оны судалгаа”,
- “Хүн худалдаалахын эсрэг гадаад улс орны эрүүгийн хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа”,
- Өмнөговь аймгийн шүүх, Нийслэлийн Баянгол, Чингэлтэй дүүргийн шүүхийн “Шүүх, шүүгч нарын ажлын ачааллыг тодорхойлох журам боловсруулах” гэх зэрэг судалгааг гүйцэтгэжээ.

Түүнчлэн нийт шүүхийн хэмжээнд дагаж мөрдөх “Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны албан ёсны статистик мэдээ, мэдээллийн тайланг хүргүүлэх заавар” боловсруулахад судалгаа хийх, санал өгөх зэргээр оролцсон байна.

Шүүн таслах ажиллагааны статистик, тоон мэдээллийг 2010 оны эхний хагас болон бүтэн жил, I, II, III, IV улирлын мэдээг нэгтгэн гаргаж, хянан холбогдох албан тушаалтан, байгууллагуудад хүргэх ажлыг зохион байгуулсан байна.

Түүнчлэн шүүхийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах, хяналт тавих ажлыг холбогдох журмын дагуу гүйцэтгэжээ. Тухайлбал:

- Ерөнхий шүүгчийн захирамж **1**,
- Шинээр хууль **121**, нэмэлт, өөрчлөлт орсон хууль **81**, хүчингүй болсон хууль **9**;
- Улсын Их Хурлын шинээр баталсан тогтоол **71**, өөрчлөлт оруулсан **9**, хүчингүй болсон тогтоол **1**;
- Улсын Дээд Шүүхийн хууль тайлбарласан тогтоол **110**;
- Тойм **9**, зөвлөмж **14**-ийг тус тус шүүхийн мэдээллийн нэгдсэн санд оруулжээ.

Мөн холбогдох судалгаа, статистик мэдээ, мэдээлэл, баримтын талаар шүүхийн ажилтан болон зарим хуульч нийт **199** хүнд лавлагаа өгсөн байна.

Иргэний хэргийн танхимтай хамтран “Иргэний эрх зүйн хамгаалалт ба шүүхийн практик” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, иргэний эрх зүйн хамгаалалт, түүний одоогийн төлөв, цаашид анхаарвал зохих зарим асуудалд судлаачдыг татан оролцуулах, шүүхийн үйл ажиллагаанд түүнийг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой боллоо.

#### **4. Санхүү, хангамж, үйлчилгээний алба.**

Улсын Дээд шүүх 2010 онд урсгал зардалд **852.5** сая төгрөг, улсын төсвөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтад **118.8** сая төгрөг, нийт **971.3** сая төгрөгийн төсөв батлуулсан билээ.

Батлагдсан төсвийг зардлын ангилал тус бүрээр зохих журмын дагуу зарцуулж, санхүүгийн мэдээ, тайланг холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь гарган өгч, ямар нэгэн байгууллага, хувь хүмүүст өр авлага гаргалгүй ажиллажээ.

Шүүгч, ажилтан, ахмадын зөвлөлийн гишүүн **31** хүнд **7,6** сая төгрөгийн буцалтгүй тусламж, эмчилгээний зардал **2** хүнд **6,0** сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж **2** хүнд **4,2** сая төгрөг нийт **17,8** сая төгрөгийг тус тус олгожээ.

2010 оны ээлжийн амралтаар өөрийн буюу эхнэр, нөхрийн төрсөн нутагт очиж амарсан **3** ажилтанд унааны зардалд **92,8** мянган төгрөгийг тооцон олгосон байна.

Гадаад томилолт, гадаад зочин болон хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлуудаас хэмнэгдсэн **18,9** сая төгрөгийг 2010 онд шүүгч, ажилтан нийт **12** хүнийг **Хон-Конг, Макао** аялуулахад зарцуулахаар холбогдох гэрээг хийж, төлбөрийг нь шилжүүлээд байна.

2010 онд үр бүтээл, санаачлага, идэвх, зүтгэл гарган ажилласан тус шүүхийн шүүгч, ажилтнууд болон бусад байгууллагын ажилтан нийт **83** хүнийг **15,9** сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.

2010 онд Улсын Дээд шүүхийн хөрөнгө оруулалтын зардлаар батлагдсан төсвөөр хөдөө ажлын хэрэгцээнд Патрол маркийн машин 1ширхэг **82,0** сая төгрөгөөр, шүүгч, ажилтнуудын үйлчилгээнд зориулж Старекс маркийн микроавтобус 1 ширхгийг **36,0** сая төгрөгөөр тус тус худалдан авч үйлчилгээнд ажиллаж байна.

Засгийн газрын 2008 оны “**Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах тухай**” 167 дугаар тогтоолын дагуу эд хөрөнгийн тооллогыг явуулж:

- **372,8 сая** төгрөгийн конторын барилга;
- **119,6 сая** төгрөгийн **2** орон сууц;
- **365,6 сая** төгрөгийн **9** автомашин;
- **402,5 сая** төгрөгийн тавилга, эд хогшил;
- **49,2 сая төгрөгийн бараа материал**;
- **0,6 сая** төгрөгийн санхүүгийн программ хангамж;
- **6,1 сая** төгрөгийн номын фонд, нийт **1** тэрбум **316,4** сая төгрөгийн эд хөрөнгө тоологджээ.

Тооллогын дүнд дутсан алга болж үрэгдсэн хөрөнгө гараагүй болно.

2011 оны төсөвт урсгал зардалд **1** тэрбум **022,9** сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд **118,8** сая төгрөг, нийт **1** тэрбум **141,7** сая төгрөг батлагдаж, 2010 оныхтай харьцуулахад нийт төсөв **17,6** хувиар буюу **170,4** сая төгрөгөөр нэмэгдлээ.

#### **5. Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын алба.**

2009 онд ХЗДХЯ, Үндэсний Архивын Ерөнхий газраас байгуулагдсан комисс “Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг”-ийн дагуу ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллаа. Тухайлбал,

- Байгууллагын хэмжээний бүх компьютерийг вирусын эсрэг програмаар хангах ажлыг зохион байгуулах,
- Өндөр хурдны интернэттэй болох ажлын бэлтгэл хангах, түүнийг ашиглах,
- Баримт бичиг боловсруулах, баталгаажуулах, бүртгэлжүүлэх, хадгалах ажлыг шинэчилсэн стандартын дагуу гүйцэтгэх,
- Тамгын газрын үйл ажиллагааны дунд хугацаан стратеги төлөвлөгөөг боловсруулах, түүнд санал авах,

- Бүрэн деффиринциал буюу хэрэглэгч, байгууллага шууд мэдээлэл солилцох, тоон технологийн шинэчилсэн хувилбараар ажиллах горим бүхий вэб сайт бүтээх ажлын бэлтгэлийг хангуулах, гүйцэтгэх зэрэг болно.

Тайлангийн хугацаанд тус алба нь нийт **421** өргөдөл гомдол, **745** албан бичиг, **3861** хавтаст хэрэг хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн, бүртгэл хяналтын карт нээж, уг албан бичгүүдийг Ерөнхий шүүгчид танилцуулсны дагуу шүүгч, ажилтнуудад хувиарлан өгч шийдвэрлүүлсэнээс гадна **4255** албан бичигт дугаар өгч холбогдох шүүх, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад явуулжээ. Өмнөх онтой харьцуулахад хүлээн авсан өргөдөл гомдол **62**-оор буурч, албан бичиг **24**-өөр, хавтаст хэрэг **1129**-өөр, явуулсан бичиг **215**-аар тус тус өсчээ.

Мөн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар шүүгчийн туслах-шинжээч Б.Батболор Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчээр, Э.Халиунбаяр Говьсүмбэр аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчээр тус тус томилогдож, Х.Цэнгэлийг Хүний нөөц, сургалтын асуудал хариуцсан ахлах референтийн албан тушаалд дэвшүүлэн, С.Батгэрэлийг Ерөнхий шүүгчийн туслах-референтийн, М.Далайхүүг Шүүгчийн туслах-шинжээчийн, Т.Жавхлантөгсийг Тамгын газрын даргын туслах-шинжээчийн албан тушаалд, М.Рэнцэндорж, Д.Мөнхнасан, Г.Бат-Эрдэнэ нарыг жолоочийн ажилд Ерөнхий шүүгчтэй зөвшилцөн Тамгын газрын даргын тушаалаар тус тус томилжээ.

Тайлангийн хугацаанд:

- Санхүү, Хангамж хариуцсан референт-Ерөнхий нягтлан бодогч **А.Эрдэнэцэцэг**, Ерөнхий шүүгчийн туслах-референт **Х.Цэнгэл**, Төсвийн асуудал хариуцсан шинжээч-нягтлан бодогч **Б.Хишигсүрэн**, Шүүгчийн туслах-шинжээч **Д.Алтанжигүүр**, **Б.Мөнхзул**, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны судалгаа хариуцсан шинжээч **Ш.Даваадулам**, Цагаатгалын ажил хариуцсан шинжээч **Л.Одончимэг**, Шүүхийн статистик, тоон мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн **Д.Оюунчимэг**, Бичиг хэрэг, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн **Г.Гандмаа** нарын 9 хүний **зэрэг дэвийг**;
- Дотоод ажил, зохион байгуулалт, хяналтын албаны дарга **Ж.Наранпүрэв**, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга **Р.Ганпүрэв**, Компьютерийн программ хангамжийн асуудал хариуцсан референт **Э.Баярбаатар**, Нийт шүүгчдийн хуралдааны зохион байгуулалтын асуудал хариуцсан ахлах шинжээч **Д.Хулан**, Судалгааны асуудал хариуцсан ахлах шинжээч **Б.Айбек**, Шүүгчийн туслах-шинжээч **М.Мөнхтөр**, **М.Баясгалан**, **Г.Солонго**, **Б.Батболор**, **Н.Дамдинсүрэн**, **Э.Халиунбаяр**, Хууль, тогтоомжийн системчлэл хариуцсан ахлах мэргэжилтэн **Ч.Жаргалсайхан**, эмч **А.Ариунболор**, жолооч **Э.Цог-Эрдэнэ** нарын **үндсэн цалингийн шатлалыг**;
- Жолооч **Э.Цог-Эрдэнийн ур чадварын** нэмэгдлийг тус тус шинээр болон нэмэгдүүлэн олгожээ.

“Билгийн тооллын хаврын тэргүүн сар - Цагаан сарын баяр”, “Хүүхдийн баяр”, “Ахмадын баярын өдөр” зэрэг тэмдэглэлт баяруудыг тохиолдуулсан арга хэмжээг тухай бүр зохион байгуулж, ойн баяр болон тэмдэглэлт өдрүүдэд Улсын Дээд шүүх дээр сахилга, хариуцлага, дэг журам, сонор сэрэмжийг өндөржүүлэх зорилгоор **5** удаагийн тушаалаар **9** ажилтныг хариуцлагатай эргүүлээр томилон ажиллуулжээ.

Тайлангийн хугацаанд **6** ажилтан төрийн өөр ажил, албан тушаалд дэвшин ажиллах болсон, өндөр насны тэтгэвэрт гарсан, өөрийн хүсэлт гаргасан зэрэг шалтгааны улмаас төрийн албанаас чөлөөлөгдөж, **2** ажилтан амаржсаны чөлөөг үргэлжлүүлэн хүүхэд асрах чөлөөг эдлэж байна.

Шүүгч, ажилтнуудын гэр бүлээс их, дээд сургуульд 2010-2011 оны хичээлийн жилд суралцаж байгаа нийт **8** оюутны “Сургалтын төлбөрийг төрөөс хариуцан санхүүжүүлэх тухай” гэрээг Сургалтын төрийн сантай байгуулж, төлбөрийг нь төлжээ.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “**4000 айл орон сууц**”-ны хөтөлбөрийн хүрээнд цагаатгалын ажил хариуцсан шинжээч Л.Одончимэг, эмч А.Ариунболор нарыг орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулж, гэрээ байгуулах ажлыг зохион байгууллаа.

Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Нийслэлийн шүүхийн нэрэмжит 2010 оны “**Шилжин явах цом**”-ын болон Хуулийн төв байгууллагуудын дунд зохион байгуулагддаг “**Шилжин явах цом**”-ын төлөө спортын 5 төрөлт тэмцээнүүдэд Улсын Дээд шүүхийн баг тамирчид амжилттай оролцож, багийн нийлбэр дүнгээр **3** дугаар байрт шалгарлаа.

### **Дөрөв. Гадаад арга хэмжээний талаар**

Шүүхийн гадаад харилцаа жилээс жилд өргөжиж, шүүгч, ажилтнууд гадаад сургалтад хамрагдах, дэлхийн болон олон улсын, тивийн, бүсийн чуулга уулзалт, эрдэм шинжилгээний бага хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны талаарх гадаад улсын туршлага судлах явдал нэмэгдэж байна. Тухайлбал,

- Иргэний хэргийн танхимын шүүгч Б.Ундрах 2010 оны 04 дүгээр сарын 15-наас 17-ны өдрүүдэд Беларусь Улсын Аж ахуйн шүүхээс зохион байгуулж буй “Эдийн засгийн хямралын үе дэх шүүхийн үйл ажиллагаа” сэдэвт чуулга уулзалтад оролцож илтгэл хэлэлцүүлээ.
- Шүүхийн Ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Н.Ганбаяр тэргүүтэй зарим анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, тамгын албаны дарга нийт 25 хүн БНХАУ-ын Ардын Дээд шүүхийн дэргэдэх “Шүүгчийн сургалтын төв”-д 2010 оны 5 дугаар сарын 24-ний өдрөөс 6 дугаар сарын 4-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Шүүхийн тогтолцоо” сэдэвт 14 хоногийн сургалтад хамрагдах ажлыг зохион байгуулав.
- Тамгын газрын дарга Д.Эрдэнэчулуун тэргүүтэй зарим давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нийт 10 хүн 2010 оны 9 дүгээр сарын 09-22-ны өдрүүдэд Тайваньд “Шүүхийн тогтолцоо” сэдэвт сургалт семинарт хамрагдлаа.
- Судалгааны төвийн захирал Ч.Нямсүрэн 2010 оны 09 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд ОХУ-ын Владивосток хотноо ОХУ-ын Арбитрын Дээд шүүхээс зохион байгуулсан “Ази номхон далайн бүсийн улс орнуудын “Хувийн өмч бол орчин үеийн эдийн засгийн харилцааны суурь” сэдэвт олон улсын 4 дүгээр форумд оролцож, “Монгол Улс дахь өмчлөлийн эрх ба бизнесийн эрх чөлөө” сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлэв.
- Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан 2010 оны 09 дүгээр сарын 27-30-ны өдрүүдэд БНХАУ-н Хонг-Конг хогноо зохион байгуулагдсан “Авилгын гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэх зарим асуудал” сэдэвт олон улсын шүүгч нарыг мэргэшүүлэх сургалт-семинарт оролцлоо.
- Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн ахлах референт Н.Долгорсүрэн нар 2010 оны 10 дугаар сарын 04-08-ны өдрүүдэд Сингапур улсад “Ази, Номхон далайн бүсийн шүүхийн шинэтгэл” сэдэвт чуулга уулзалтад оролцоод ирлээ.
- Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан, шүүгч Б.Бат-Эрдэнэ нар 2010 оны 10 дугаар сарын 25-ний өдрөөс 11 дүгээр сарын 5-ны өдрүүдэд Ханнс Зайдел сангийн шугамаар ХБНГУ-ын Мюнхен мужид “Эрүүгийн эрх зүйн сургагч багшийг бэлтгэх, эрүүгийн хэргийг шийдвэрлэх, хууль хэрэглэхэд шүүгчийн сургалтын үр нөлөө” зэрэг асуудлаар туршлага судаллаа.
- Шүүгч Л.Бямбаа, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн ахлах-референт Н.Долгорсүрэн нар 2010 оны 12 дугаар сарын 6-17-ний өдрүүдэд БНЭУ-ын **Лакнау** хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн Ерөнхий шүүгчдийн 10 дугаар бага хурал”-д тус тус оролцжээ.

Түүнчлэн гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд:

- “Хууль зүйн салбарын үйлчилгээг сайжруулах нь” төслийн удирдагч Хайке Грамкоу, “Дэлхийн банк”-ны ажилтан Франсис Ален нар 2010 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчтэй уулзаж, хамтын ажиллагааны зарим тодорхой асуудлаар санал солилцлоо.
- БНХАУ-ын Хуульчдийн нийгэмлэгийн дарга Гу Жаомин, албаны бусад хүмүүс 2010 оны 7 дугаар сарын 01-ний өдөр Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчтэй уулзаж, хоёр орны шүүн таслах ажиллагаа, хуульч бэлтгэдэг систем, шүүхийн бүтэц зохион байгуулалтын талаар харилцан санал солилцжээ.
- БНХАУ-ын Бүх Хятадын Өмгөөлөгчдийн холбооны төлөөлөгчид 2010 оны 7 дугаар сарын 07-ны өдөр Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгчтэй уулзаж, хоёр орны хуульчдын хамтын ажиллагаа, шүүгчдийн сургалт, хамтарсан судалгаа, эрдэм шинжилгээний ажлын талаар харилцан санал солилцож, Монгол улсын шүүхийн бүтэц, зохион байгуулалтын тухай ярилцлаа.
- Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч БНСУ-ын Барын холбооны төлөөлөгчдийг 2010 оны 7 дугаар 14-ний өдөр хүлээн авч уулзаж, хоёр орны шүүгчдийг бэлтгэх, мэргэшүүлэх талаар харилцан санал солилцов.

#### **Тав. Сургалт, семинарын талаар**

2010 оны байдлаар Улсын Дээд шүүх дараах сургалт, семинарыг зохион байгууллаа. Үүнд:

- 2009 оны 2 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд Анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Тамгын хэлтэс, албаны дарга нарын 2010 оны **нэгдсэн зөвлөгөөнийг** Улсын Дээд шүүхийн байранд зохион байгууллаа.
- 2010 оны 03 дугаар сарын 24-нөөс 26-ны өдрүүдэд Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч Л.Атарцэцэг Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн шүүхийн шүүгчдэд “Шүүгчийн ёс зүй”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79, 90 дүгээр



- зүйлийг хэрэглэж буй шүүхийн практикийн тухай”, “Шүүхээр газрын маргаантай хэрэг хянан шийдвэрлэхэд анхаарах зарим асуудлууд”, “Захиргааны актын төрөл” сэдвүүдээр хичээл зааж, сургалт зохион байгуулж харилцан санал солилцсон байна.
- 2010 оны 03 дугаар сарын 15-наас 19-ний өдрүүдэд “Хуулийн дагуу үүсэх үүргийн харилцаа ба иргэний хууль хэрэглэх, шүүхийн шийдвэр боловсруулах аргачлал”, “Иргэний хэргийг анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэх журам” сэдвээр Иргэний хэргийн танхимын шүүгч-багш нар үзэл баримтлалаа боловсруулжээ.
  - Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Улсын Дээд шүүхийн шүүгч нарт зориулан “Хуульчийн үргэлжилсэн сургалт”-ын “Нийтлэг эрх зүй”-н сургалтыг 6 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд зохион байгуулж, зохих кредит цагийг тооцон олголоо.
  - 2010 оны 6 дугаар сарын 16-18-ны өдрүүдэд Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа Орхон аймагт Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, шүүгчийн туслахууд зориулсан “Шүүгчийн ёс зүй”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 79, 90 дүгээр зүйлийг шүүхийн практикт хэрэглэх тухай” сэдвүүдээр хичээл зааж, сургалт зохион байгуулж харилцан санал солилцсон байна.
  - 2010 оны 6 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Эрүүгийн хэргийн танхимын шүүгч, шүүгчийн туслах нар Өвөрхангай аймагт Архангай, Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгчид, шүүгчийн туслах нарт зориулсан “Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зарим зүйл, заалтыг зөв хэрэглэх нь” сэдэвт сургалтыг зохион явууллаа.
  - 2010 оны 6 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Иргэний хэргийн танхимын шүүгч, шүүгчийн туслах нар Сэлэнгэ аймагт Сэлэнгэ, Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгчид, шүүгчийн туслах нарт зориулсан “Иргэний шүүн таслах ажиллагаа” сэдэвт сургалтыг зохион байгуулжээ.
  - 2010 оны 6 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд шүүгч Д.Пунцаг “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дахь нотолгоо” сэдэвт сургалтыг Дундговь, Өмнөговь аймгуудад удирдан явууллаа.
  - 2010 оны 9 дүгээр сарын 30-ний өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд Захиргааны хэргийн танхимын шүүгч, шүүгчийн туслах нар Өмнөговь аймагт Өмнөговь, Дундговь аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчид, шүүгчийн туслах нарт зориулсан “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалтыг зохион байгуулжээ.

Тайлангийн хугацаанд бусдаасаа илүү идэвх, зүтгэл, үр бүтээл гарган ажилласан Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Д.Батсайхан, Иргэний хэргийн танхимын тэргүүн Ц.Амарсайхан, Захиргааны хэргийн танхимын тэргүүн О.Зандраа, шүүгч Л.Атарцэцэг, Б.Бат-Эрдэнэ, А.Доржготов, С.Нямжав, Ц.Сумъяа, Д.Тунгалаг, Б.Ундрах, албаны дарга М.Дамирансүрэн, Р.Ганпүрэв, референт Э.Баярбаатар, ахлах шинжээч Д.Хулан, шүүгчийн туслах Д.Алтанцэцэг, Г.Солонго, Б.Мягмаржав, шинжээч Л.Одончимэг, ахлах мэргэжилтэн Г.Гандмаа, жолооч С.Баянмөнх, үйлчлэгч Б.Уртнасан, Ц.Цэцэгсүрэн нарт хамт олныхоо нэрийн өмнөөс болон хувиасаа талархал илэрхийлж, ажилд нь амжилт хүсье.

### **Эрхэм шүүгч, ажилтнууд аа!**

Улирч буй 2010 онд бид амжилт бүтээл арвин байлаа. Морилон ирж буй 2011 онд түүнээс ч их зүйлийг хийж, амжуулах шаардлагатай бөгөөд үүнд та бүхнийг идэвхи санаачлага, итгэл зүтгэл, үр бүтээл гарган ажиллана гэдэгт эргэлзэхгүй байна.

Та бүхний цаашдын ажилд амжилт, эрүүл энхийг хүсье.